

Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажиллах нөхцлийг бий болгох чиглэлээр гаргасан эрх зохицуулалт тодорхой хэмжээгээр байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй. шаардлагатай хөрөнгө нь төсөвт суугаагүй. нөгөө талаараа цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажлын байрны стандарт шаардлага байхгүй байгаа нь өнөөгийн байдлаар шаардлагатай ажлын байрны орчин нөхцлийг бүрдүүлэхэд учирч байгаа хүндрэл бэрхшээл юм байна гэж үзлээ.

Санал.

1. ЦЕГ-ын удирдлагаас санаачлан цагдаагийн хэсгийн төлөөлөгч нарын ажлын байрны орчин нөхцлийг судлах ажлын хэсэг байгуулан, шаардагдах хөрөнгө, мөнгөний тооцоо гаргах;

2. Цагдаагийн хэсгийн төлөөлөгчийн ажлын байрны орчин нөхцөл, шаардлагатай бусад байдлыг тусгасан стандарт шаардлагыг боловсруулж, Цагдаагийн албаны тухай хуулинд тусгах;

3. Цагдаагийн хэсгийн төлөөлөгч нарын ажлын байрны орчин нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр гаргасан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг судлах ажлын хэсэг байгуулан судлуулж, хэрэгжилтэнд тулгарч хүндрэл бэрхшээл, түүний шалтгаан нөхцлийг илрүүлэх ажлыг зохион байгуулах.

*Б.Энх-Амгалан - ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 8032 дугаар дамжааны суралцагч,
цагдаагийн хошууч*

*Д.Энхбаяр - ХСИС-ийн Удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын
багийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭР ХҮНД, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ, ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН ҮНЭЛЭМЖ

Хураангуй: Энэхуу илтгэлээр цагдаагийн байгууллагын нэр хүнд, түүнд нөлөөлөх хүчин зүйл, иргэд, олон нийтийн зүгээс өгч буй үнэлэмж зэрэгт дун шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорилоо.

Түлхүүр уг: Цагдаагийн байгууллага, Нэр хүнд, Алба хаагч

Аливаа төрийн болон хууль сахиулах тусгайлсан чиг уургийг хэрэгжүүлэгч байгууллагын өмнөө тавьсан зорилго, зорилтоо ханган биелүүлэх, амжилттай ажиллах нь олон чухал хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд тууний нэг нь удирдлагын зөв, оновчтой арга барилыг бух шатанд нэвтрүүлэх, улмаар иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэг, тусалцааг байнга авахад оршиж байдаг.

Цагдаагийн байгууллага¹ нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн. Хэдийгээр энэхүү чиг үүрэг нь хуулиар цагдаагийн байгууллагад ногдож байгаа ч түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн дэмжлэг, туслалцаа, итгэл туйлаас чухал бөгөөд цаашлаад энэ нь цагдаагийн байгууллагын нэр хүндтэй шууд холбоотой нийгмийн нэг томоохон асуудал болон урган гарах учиртай.

Ер нь аливаа байгууллагын нэр хүнд аяндаа өөрөө бий болдог нийгмийн үзэгдэл огтоос биш гэдгийг ч бид өмнөх бүлэгт маш тодорхой авч үзсэн бөгөөд энэ нь алба хаагч бүрийн хичээл зүтгэл, шат шатны удирдах албан тушаалтны удирдлагын зөв арга барил, түүний хэрэгжилт, хүч чармайлт, олон жилийн шаргуу хөдөлмөр зэрэг олон талт үйл ажиллагааны үр дүнгээр бодит биелэлээ олж байж сая хүсэн хүлээсэн нэр хүнд, итгэл үнэмшлийг олж авах учиртай.

Тэгвэл *"Цагдаагийн байгууллагын нэр хүнд гэж юу вэ?"* гэсэн асуулт зүй ёсоор урган гарна.

Судалгааны ажлын өмнөх бүлэгт бид *"Байгууллагын нэр хүнд"* гэсэн тодорхойлолтыг дэвшүүлсэн бөгөөд энэхүү ерөнхий тодорхойлолт болон цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, түүний гүйцэтгэх үйл ажиллагааны онцлог зэрэгт үндэслэн *"Цагдаагийн байгууллагын нэр хүнд"* гэсэн тодорхойлолтыг анх удаа дэвшүүлж байна. Үүнд:

Цагдаагийн байгууллагын нэр хүнд - Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй үйл ажиллагааны бодит байдал, алба хаагчдийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, сахилга хариуцлагын илрэх хэлбэрт хөндлөнгөөс² өгч буй үнэлэмж.

Эндээс *"Өнөөдөр цагдаагийн байгууллагын нэр хүнд ямар түвшинд байна вэ?"* Цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийтийн итгэл, хүндлэлийг тууштай авч чадаж байна уу?" зэрэг олон асуултын хариултад цагдаагийн байгууллага *"маш сайн"* гэсэн үнэлгээг итгэл төгс сонсох нь бас л эргэлзээтэй.

Хэдийгээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийсэн ажлын тайланд цагдаагийн байгууллагад иргэд, олон нийтийн сэтгэл ханамж *"сайн байгаа"* гэж дүгнэсэн ч цаашид хууль журмыг чанд сахих, стандартын дагуу ажиллах, өргөдөл, гомдолыг түргэн

¹Цагдаагийн албаны тухай хууль. 4 дүгээр зүйл. 4.1. дэх хэсэг.

²Хөндлөнгөөс гэж иргэд, олон нийтийг ойлгоно.

шуурхай шийдвэрлэх. үйл ажиллагаа. мэдээллийн шуурхай байдлыг хангах. ажлаа ил тод. нээлттэй таниулан сурталчилах. алба хаагчдын зан харилцаа, мэдлэг. боловсрол. ур чадвар. ёс зүй. үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай байгааг дурьдсан байна¹.

Цагдаагийн байгууллагын нэр хүндэд хэрхэн эерэг болон сөргөөр нөлөөлж байгаад үнэлэлт. дүгнэлт өгөхийг зорилоо. Үүнд:

Нэг. Удирдлагаас хэрэгжүүлж байгаа бодлого. үйл ажиллагаа цагдаагийн байгууллагын нэр хүндэд нөлөөлж буй байдал.

Монгол орны тусгаар тогтнол. ард түмэн, албаны нэр хүнд нь цагдаагийн алба хаагч бүрийн бишрэн дээдлэх үнэт зүйл байх учиртай^{1 2 3}.

Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсан цагаасаа улс орны нийгэм, төрийн байгууламжийн хөгжлийн бүхий л үе шатад өөрийн хөгжлийн чиг баримжаагаа олж, хөгжиж, бэхжиж ирсэн, төрийн тогтолцоонд байр суурь нь харьцангуй тогтвортой болсон хууль сахиулах байгууллага юм. Өнөөдөр тус байгууллага нь удирдлага, цагдаагийн төв, нутаг дэвсгэр хариуцсан байгууллага, харъяа нэгж гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн хөгжил, түүний чиг хандлагаас шалтгаалан цагдаагийн алба хаагчдын санаа бодолд гарч буй өөрчлөлт, түүнчлэн судалгааны ажлын явцад цагдаагийн алба хаагчдаас "Та өөрийн эрхэлж буй ажилдаа хэрхэн сэтгэл ханамжтай байдаг вэ?" гэсэн санал асуулгын үр дүн зэргээс үзэхэд алба хаагчид өөрийн мэргэжил, албандаа төдийлөн сэтгэл ханамжтай бус байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 46 хувь нь "эрхэлсэн ажилдаа сэтгэл ханамж дундуур" гэж хариулсан ба түүнийгээ ажлын ачаалал их³, илүү цагийн цалин хөлс авдаггүй. албаны онцлог, стрессээс үүдэлтэй зан авирын өөрчлөлттэй болж, иргэдтэй харилцах харилцаанд муугаар нөлөөлдөг, карьерын болон хариуцлагын шударга тогтолцоо бүрдээгүй зэрэгтэй холбон тайлбарласан байна.

Нөгөө талаар нийгмийн ёс суртахууны үнэлэмж доройтож иргэд, олон нийтийн зүгээс цагдаагийн алба хаагчийг албан үүргээ хэрэгжүүлж байгаатай нь холбогдуулан дорд үзэх, гүтгэх, хэл амаар болон элдэв үйл хөдлөлөөр

¹ Цагдаагийн ерөнхий газар, Судалгаа, шинжилгээний Эс Ай Си Эй ХХК. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн үнэлгээ. судалгааны ажлын тайлан. УБ., 2015. 19-20 дахь тал.

²Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги (2016-2028) төсөл. УБ., 2016.

³ 100000 хүнд ноогдох цагдаагийн ажилтны тоогоор дэлхийн дундаж үзүүлэлтээс 83,1 хувиар бага байдаг нь судалгаагаар тогтоогджээ.

доромжлох болсон нь цагдаагийн байгууллагын нэр хүнд олон түмний дунд буурахад нөлөөлж буй хамгийн том сөрөг хүчин зүйл болж байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын удирдлагын хэрэгжилтэд улс төрийн нөлөөлөл ихэссэнээр түүний бие даасан, хараат бус, үйл ажиллагааны тогтвортой байдал, залгамж холбоо алдагдах, улмаар шат шатны удирдах албан тушаалтны томилгоонд ч нөлөөлдөг болсон төдийгүй цагдаагийн төв байгууллагын удирдлагууд солигдох бүрт нэгж дээр үүрэг гүйцэтгэж байгаа мэргэшсэн алба хаагчдын шилжилт хөдөлгөөн бүх шатанд давхар хийгддэг болсон нь цагдаагийн байгууллагын нэр хүнд буурахад нөлөөлж байгаа голлох сөрөг хүчин зүйл болж байна.

Мөн бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл нэрийн дор хийгдэж байгаа удаа дараагийн өөрчлөлт¹ нь алба хаагчдын тогтвор суурьпилтай ажиллах, тэдний албанд хандах хандлага, итгэл үнэмшил, цаашлаад цагдаагийн байгууллагын нэр хүнд буурахад хамгийн их сөрөг нөлөөлөлийг бий болгож байгаа нь судалгаагаар тогтоогджээ^{1 2}.

Харин цагдаагийн байгууллагын имиж, дүр төрхийг (*өөрөөр хэлбэл, олоо түмний дунд нэр хүнд нь ямар байгааг*) бодитоор тодорхойлох зорилгоор иргэдийн дунд явуулсан тандах судалгааны “Таны цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг ямар түвшинд байна гэж үздэг вэ?” гэсэн асуултанд нийт оролцсон иргэдийн³ 77.0% (158) нь “цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа” гэсэн хариултыг сонгосон нь иргэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд итгэл, үнэмшилтэй байгаа төдийгүй албаны нэр хүнд нь харьцангуй тогтвортой түвшинд байгааг харуулж байна.

Гэвч мөн л удирдлага тогтворгүй, ойр ойрхон солигдож, халаа сэлгээ хийгддэг, цагдаагийн төв байгууллага болон бүтцийн нэгжийн газар,

¹ Цагдаагийн албыг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн тусгай алба статусыг хуулиар тогтоож хуулийн энэхүү шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах бүтэц, зохион байгуулалтыг бий болгохтой холбоотой Засгийн газрын 2013 оны 405, 2014 оны 387, 2015 оны 501 дүгээр тогтоолоор цагдаагийн төв байгууллагын орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсан. Үүний дагуу Хууль зүйн сайдын тушаалаар 2013-2015 онд ЦЕГ-ын зохион байгуулалтын бүтэц нийт 5 удаа шинэчлэн батлагдсан. Хууль зүйн сайдын дээрх тушаалуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЦЕГ-ын даргын тушаалаар төв, орон нутаг дах харьяа нэгжүүдийн бүтэц, зохион байгуулалтыг 2014 онд 10, 2015 онд 15, 2016 онд 3, 2017 онд 1 удаа тус тус өөрчилөн шинэчилсэн байна.

² Цагдаагийн албанаас гарах хөдөлгөөнийг сүүлийн 4 жилээр дундачлан үзвэл 438 офицер. 404 ахлагч гарсан ба энэ нь жилд дунджаар 842 алба хаагч буюу 9 орчим хувь нь цагдаагийн албанаас гарч байна. Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн хөгжлийн стратеги (2016-2028) төслийн судалгааны ажил. УБ., 2016.

³ Цагдаагийн байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны чанарт үнэлгээ өгөх санал асуулгад нийтдээ 205 иргэн оролцсон.

хэлтсүүдийн ажлын уялдаа холбоо, ажил үүргийн хуваарь оновчтой бус, давхардал ихтэй, орчин үеийн өндөр техник, технологи нэвтэрч цахимжуулаагүй, бодлогын баримт бичгийн хэрэгцээ шаардлагыг үндэстэй боловсруулж удирдлагын оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хэрэгжилт сул. иргэдийн гомдол. хүсэлтийг шуурхай шийдвэрлэх хүн, хүч дутагдалтай, алба хаагчдын албандаа хандах сэтгэл ханамж, итгэл буурсан. гэмт хэрэг, зөрчилд удаа дараа холбогдож дутагдлаар халагдаж, чөлөөлөгдөж байгаа, нөхөн хангалтын залгамж холбоо. насны тэнцвэрт байдал алдагдсан, мэргэшсэн, тогтвор суурьшилтай ажиллах хүний нөөцийн цогц бодлого хэрэгжидгүй зэрэг нь цагдаагийн байгууллагын удирдлагыг шат шатанд нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд оршиж байгаа бас нэг сул талыг бий болгож байна.

Цагдаагийн байгууллагын нэр хүнд унах, таарамжгүй байх шалтгаан нөхцлийг тоочохын оронд *“Яагаад ийм байдалд хүрэв? Хэрхэн хурдан залруулж, алдаж байгаа нэр хүндийг эргүүлэн олж авах вэ?”* гэдэг нь чухал.

Судалгааны ажлын хүрээнд энэхүү нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах бодлогын шинжтэй арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, цаг үе нь болсон гэж үзлээ. Үүнд:

1. Бүтэц, зохион байгуулалтын удаа дараагийн өөрчлөлт нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ шуурхай хэрэгжүүлэх, түүнийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар найдвартай хангахад сөрөг нөлөө үзүүлж байгаад дүгнэлт хийж, үйл ажиллагаа, түүний удирдлагыг бодитойгоор хангахад чиглэсэн хамгийн оновчтой, тогтвортой, давхцалгүй, зохион байгуулалтын бүтцийг бий болгож хэвийн ажиллах орчныг бүрдүүлэх, түүнчлэн цагдаагийн албыг мэргэшсэн, тогтвортой байх нөхцөлийг хангаж хариуцлагын тогтолцоог шат шатанд бий болгох, сайжруулах;

2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг өргөнөөр ашиглан мэдээлэл, холбооны хоцрогдлыг арилгаж албаны найдвартай, шуурхай, ил тод байдлыг хангахад чиглэсэн иж бүрэн шинэчлэлтийг шуурхай нэвтрүүлэх;

3. Эрсдэлд суурилсан төлөвлөлт, удирдлага, хяналтын системийг бий болгож эрсдлийг бууруулах. саармагжуулах цогц бодлого, хөтөлбөрийг боловсруулж цагдаагийн байгууллагын нэр хүндэд нөлөөлөх эрдслийн удирдлагыг нэгж, алба бүрт үр дүнтэй нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэлээ.

Хоёр. Удирдах албан тушаалтны үйл ажиллагаа цагдаагийн байгууллагын нэр хүндэд нөлөөлж буй байдал.

Цагдаагийн байгууллагын хогжил, соёлын төлөвшилт, нэр хүндийг дээшлүүлэхэд шат, шатны удирдах албан тушаалтны манлайлал, удирдлагын арга барил, ур чадвар ихээхэн үүрэг гүйцэтгэх болж байна.

Түүгээр ч барахгүй цагдаагийн удирдах албан тушаалтан тал бүрийн мэдлэгтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйн зов төлөвшилтэй, соёлтой, удирдлагын олон талт арга барилтай, багаар ажиллах чадвартай, түүнчлэн нийгмийн хөгжлийн онцлог, чиг хандлагыг зөв танин мэдэх, дүн шинжилгээ хийх, түүнийг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгтэй уялдуулан холбож цаг үедээ нийцсэн, оновчтой шийдвэр гаргах зэрэг олон талын ур чадвар эзэмшсэн байхыг өнөөгийн цаг үе шаардаж байна.

Энэ бүхэн удирдах албан тушаалд томилогдсон даруйд шууд аяндаа бий болчихгүй бөгөөд энэхүү нийтлэг шалгуур, шаардлагад бүрэн нийцсэн цагдаагийн чадварлаг удирдах албан тушаалтан байхын тулд хувь хүнээс ихээхэн хүч чармайлт, өндөр хариуцлага, ур чадварыг шаардах нь мэдээж.

Нөгөө талаар цагдаагийн байгууллагын нэр хүнд ямар түвшинд байх нь шат шатны удирдах албан тушаалтнаас ихээхэн хамааралтай төдийгүй түүний дараах шинж чанар үүнд голлох үүрэг гүйцэтгэх учиртай. Энэ нь:

> удирдах албан тушаалтны удирдлагын арга барил, мэргэжлийн болон зохион байгуулах ур чадвар;

> удирдах албан тушаалтны ёс зүйн төлөвшил, соёл, харьцаа;

> удирдах албан тушаалтны манлайлал; үлгэр дууриал;

> удирдах албан тушаалтны имиж;

> удирдах албан тушаалтны албаны нэр хүнд, хамт олны дунд эзлэх байр суурь;

> удирдах албан тушаалтан, олон нийтийн хамтын ажиллагаа юм.

Судлаач У.Мөнхсансар¹ өөрийн судалгааны бүтээлдээ цагдаагийн удирдах албан тушаалтан"-ы тодорхойлолтыг анх удаа дэвшүүлэн гаргасан бөгөөд үүнтэй бид санал нэг байна.

Цагдаагийн удирдах албан тушаалтан - Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн уялдаа холбоог хангахаар зохион байгуулагдсан дагнасан төрөл мэргэжлийн албадын нэгдмэл төвлөрсөн удирдлагыг бүх шатанд тууштай хэрэгжүүлэх цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, нутаг дэвсгэрийн байгууллага, тэдгээрийн нэгжийн үйл ажиллагааг мэргэжлийн болон зохион байгуулалтын удирдлагаар тасралтгүй хангаж байгаа удирдах алба хаагч.

¹ Мөнхсансар У. Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтны имижийн зарим асуудал. магистрын судалгааны ажил. УБ., 2017. 41 дэх тал.

Тэгтэл цагдаагийн байгууллагын нэр хүндэд хамгийн их сөрөг нөлөө үзүүлэх сөрөг хүчин зүйл бол удирдлагын буюу удирдах албан тушаалтны аливаа хэлбэрийн хүнд суртал. чирэгдэл байдаг.

Түүнчлэн "Хүнд суртал гэж чухам юу вэ?" гэдгийг тал бүрээс нь ойлгож түүнд зөв үнэлэлт дүгнэлт өгөх нь чухал юм. Тухайлбал, нэг талаас. цагдаагийн албаны онцлог. үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар тогтоосон хууль эрх зүйн акт. дүрэм, журамд заасан нийтлэг шаардлагыг хэн нэгнээс биелүүлэхийг шаардсаныг эсэргүүцэж. өөрөө ухамсартайгаар хүлээн аваагүйгээс гаргасан дотоод сэтгэлийн илэрхийлэл, уур бухимдалын буруугаа бусдаас хайж "хүнд суртал" гаргалаа гэж үздэг нэг хэсэг байхад. нөгөө талаас. үнэхээр элдэв шат дамжлага. цагийн хуваарь, дотоод журам нэрээр бусдыг чирэгдүүлж, цагдаагийн албаны ил тод, шуурхай байдлыг хангаагүйгээс үүдэлтэй бодит хэлбэрийн хүнд суртал өнөөдөр байсаар байгаа нь нууц биш.

Аливаа харилцаа харилцан хүндэтгэл дээр оршиж байж сая амжилтанд хүрдэг. Нөгөө талаар хүн болгоны хүсэл сонирхол, сэтгэл ханамж, эрх ашгийг бүрэн хангаж байдаг байгууллага, удирдлага, удирдах албан тушаалтан гэж байхгүй нь онолын хувьд тодорхой бөгөөд энэ нь мэдээж үл гүйцэлдэх шинжтэй бөгөөд, боломж нөхцөлөөр хязгаарлагдмал харьцангуй ойлголт юм.

"Цагдаагийн байгууллагын шат шатны удирдах албан тушаалтан ямар байх ёстой? Тэдэнд ямар шалгуур шаардлагатай вэ?"

Цагдаагийн удирдах албан тушаалтны зохион байгуулах арга барил, мэргэжлийн ур чадвар, туршлага, нэр хүнд, өөртөө итгэлтэй байх, саад бэрхшээлийг урьдчилан харах, алба хаагчдыг ажиллах таатай нөхцөл боломжоор хангах, тэдний урам зориг, идэвхи, сонирхлыг өрнүүлэх, дэмжих, хамт олны дунд халуун, дотно уур амьсгал бий болгох зэрэг олон талт хэлбэрийн нэгдмэл удирдлагаас цагдаагийн аль ч нэгж, байгууллагын ажлын амжилт, нэр хүнд ихээхэн хамаарч, улмаар энэ бүхнээр орчин цагийн цагдаагийн удирдах албан тушаалтны нийтлэг төрх төлөвшин тогтож, улмаар энэ нь эргээд өргөн утгаараа цагдаагийн байгууллагын нэр хүнд, түүний үнэлэмж олон нийтэд ямагт өндөр байхад эерэгээр нөлөөлөх учиртай.

Тиймээс ч цагдаагийн шат шатны удирдах албан тушаалтан хүний эрх. эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, төрийн болон хувийн нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж бусдын дэмжлэгийг авах, багаар ажиллах, нутгийн өөрөө удирдах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийттэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг бүтээлчээр ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагын үндсэн зарчмыг тууштай хангаж ажиллах нь тэдэнд тавигдах энэ тэргүүний шалгуур, шаардлага болж байна.

Гэвч сүүлийн үед цагдаагийн зарим удирдах албан тушаалтны шударга бус үйл ажиллагаа, сахилга, ёс зүйн зөрчлөөс дээрхи зарчим алдагдаж, энэ талаар иргэд, олон нийтийн шүүмжлэл байнга гарч, тэр чинээгээр албаны нэр унаж байгаад дүгнэл г хийж ажиллах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

Түүнчлэн цагдаагийн байгууллагын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн 2.2 дахь хэсэгт "анхан болон дунд шатны удирдлагын менежмент сул, ур чадвар дутагдалтай" гэж дүгнэсэн байна^{1 2}.

Цагдаагийн шат шатны удирдах албан тушаалтны үүрэг хариуцлага, манлайллыг дээшлүүлэх нэн тэргүүний зорилт бөгөөд гадны зарим судлаач, шинжээчид "Монгол Улсын цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэлийг хийх нь цагдаагийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх үндсэн нөхцлийг бүрдүүлнэ" гэж дүгнэж, олон улсын, өргөн цар хүрээтэй, урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурласан шинэтгэл хийх замаар цагдаагийн ажлыг мэргэжлийн түвшинд хүргэж, ард иргэдийн итгэлийг эргэн олж авах, зөвлөлт маягийн цагдаагийн арга барилаас орчин үеийн өндөр хөгжилтэй улс, орны цагдаагийн загварт шилжихэд Монгол Улсын Засгийн газар, цагдаагийн төв байгууллага болон олон улсын холбогдох байгууллагуудын байнгын анхаарал, идэвхтэй оролцоо шаардлагатай хэмээн зөвлөсөн байдаг.

Судалгаагаар цагдаагийн байгууллага хүнд сурталтай, цагдаагийн алба хаагчид дээрэнгүй, харьцааны соёлгүй, мэдлэг, мэргэжлийн ур чадваргүй, иргэдтэй тэгш бус харьцдаг, цагдаагийн удирдах албан тушаалтнаас албан хаагчдын ажил үүргийн хараат бус байдалд нөлөөлдөг, танил тал, мөнгөтэй хүнд үйлчилдэг гэж олон нийт дүгнэсэн байна.

Цагдаагийн байгууллагаас үзүүлж байгаа ажил үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг судлахад 70 орчим хувь нь "дунд буюу түүнээс доош" үнэлгээ өгч, харин алба хаагчдын харилцааны соёлын тухайд 50 хувь нь "хангалтгүй" үнэлгээ өгчээ.

Түүнчлэн байгууллагын соёл төлөвшөөгүй, үнэт зүйл болж чадаагүй, хүний нөөцийг сонгон шалгаруулт шинэчлэгдээгүй, удирдах албан тушаалтныг бэлтгэх тогтолцоо бий болоогүй, шинэ мэдээлэл олж авах арга барилд суралцаагүй, багаар хамтран ажиллах чадвар муутай, төсөв хомсдолтой, зарцуулалт оновчтой биш зэрэг олон бэрхшээл, сул тал байсаар байгаа мөн л цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна³.

¹ ЦЕГ-ын даргын 2015.03.20-ны өдрийн 6/169 тушаалын хавсралт.

² Цагдаагийн ерөнхий газар. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирсон цагдаагийн алба хаагчдын өнөөгийн байдал, судалгааны ажлын тайлан. -УБ. 2016.

³ Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 79 дүгээр тогтоол.

Мэдээж энэхүү бодит өөрчлөлт, шинэчлэлтийг хийж, өндөр хөгжилтэй улс орны цагдаагийн байгууллагын жишигт хүрэх зам ярих төдийд биелэлээ олох зүйл биш бөгөөд үүнд зөв бодлого, менежмент, үе шаттай, урт хугацааны төлөвлөлт, төсөв санхүү, алба хаагч, түүний дотор цагдаагийн байгууллагын шат шатны удирдах албан тушаалтны манлайлал¹ туйлаас чухал.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын анхан болон дунд, зарим үед дээд түвшний удирдлагад ч хуулиар олгосон эрх хэмжээгээ хэтрүүлэх, хэрэгжүүлэхгүй хөшүүн хойрго хандах, аливаа асуудлыг дангаар бие дааж шийдвэрлэх, гаргасан шийдвэр нь цаг үеэ олохгүй байх, хувийн тааламжгүй зан харьцааны дутагдалаа удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх, байгууллага, хамт олныг удирдах явцад мэдэж авсан албаны болон хувь хүний талаархи мэдээ, мэдээллийг хувийн эрх ашиг болон бусад зорилгод ашиглах, бусдын амжилт бүтээлийг үнэлэхгүй дарагдуулах, зарим нэгэнд тал засаж тэднийг үргэлж дэмжих, урамшуулах зэрэг хэлбэрийн удирдлагын гаж буруу арга барил, бүрдэж байгаа нь нууц биш.

Одоо "Цагдаагийн удирдах албан тушаалтны сахилга, ёс зүй ямар түвшинд байна вэ?" гэдэгт анхаарал хандуулья.

Сүүлийн үед цагдаагийн алба хаагчдаас, түүний дотор удирдах албан тушаалтнаас ч гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдахаас гадна сахилга, харилцааны ёс зүйн зөрчил гарган иргэдийн дунд цагдаагийн байгууллагын нэр хүндийг бууруулах явдал гарсаар байгаа нь хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд байнга дурьдагдаж улмаар цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаанд сөрөг үр дагаварыг бий болгож байна. Тухайлбал, 2013-2016 онд цагдаагийн хэлтэс, тасгийн дарга нараас 14 удирдах албан тушаалтан гэмт хэрэгт холбогдож шалгагдсан нь нийт гэмт хэрэгт холбогдож шалгагдсан алба хаагчийн 4,29 хувийг эзэлж байгаа нь бага бус үзүүлэлт².

Энэ бүхнээс дүгнэхэд цагдаагийн удирдах албан тушаалтнаас үйлдсэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тусгайлан судлан тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, ялангуяа тэдний харилцааны соёл, ёс зүйг дээшлүүлэх ажлыг үр нөлөөтэй зохион байгуулах шаардлага бий болсон нь харагдаж байна. Ийнхүү цагдаагийн удирдах албан тушаалтны

Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. Цахим эх сурвалж, холбоос:
<http://www.legalinfo.mn/annex/details/6264?lawid=9842>

¹ Манлайлал бол нөлөөлөх чадвар. Манлайлал нь хувь хүн ба бүлэг хүмүүсийг зорилгод нь хүргэх үйл ажиллагаанд өдөөж өгөхийн тулд нөлөөлөх ур чадвар юм.

² Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газар. Судалгаа, дүн шинжилгээний төв. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал. судалгааны ажлын тайлан. УБ., 2016. 7 дахь тал.

сахилга, ёс зүй тодийлөн сайнгүй байгаа нь гадаад, дотоод олон хүчин зүйлийн нөлөөлөлтэй холбоотой боловч үүний гол шалтгаан нөхцөлийн нэг шат шатны удирдах албан тушаалтны ажлын арга барил, ур чадвар хэт хоцорсон, өнөөгийн эрх зүйн соёл, шаардлагыг хангахгүй байгаатай шууд холбоотой.

Гурав. Алба хаагчийн үйл ажиллагаа цагдигийн байгууллагын нэр хүндэд нөлөөлж буй байдал.

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн жинхэнэ алба хаагчийн нийтлэг үүргийг тодорхойлж, түүний 13.1.5. дахь хэсэгт төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх¹ тухай заасан нь төрийн тусгай алба хаагч болох цагдаагийн алба хаагчдад нэгэн адил хамааралтай заалт юм.

Гэвч цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйлдэл, тухайлбал, сахилга, ёс зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдсон гомдол, мэдээлэл буурахгүй байгаа нь иргэд, олон нийтээс цагдаагийн байгууллагад итгэх итгэл буурах, цаашлаад цагдаагийн байгууллагын нэр хүнд унах бас нэг хүчин зүйл болж байна.

Түүнчлэн судалгаагаар хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийн заалт, шаардлагыг биелүүлэхгүй улмаас гэмт хэргийн нотлох баримтын чанар алдагдах, хэргийн нотлох баримт хуурамчаар бүрдүүлэх, хэргийг хэт нэг талыг барьж шалгах, бусдыг чирэгдүүлж танил тал харах, шан харамж, авлигад өртөх, хүний эрх зөрчих, албан тушаалдаа хайнга хандах, хүнд суртал гаргах зэрэг гэмт хэрэг, зөрчил буурахгүй байгаа цагдаагийн албаны нэр хүндэд хамгийн том сөрөг хүчин зүйл болж байна^{1 2}.

Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдож байгаа шалтгаан нөхцлийг авч үзвэл ихэнх тохиолдолд хувь хүний төлөвшил, ёс зүйтэй холбоотой боловч түүнчлэн албандаа хайнга хандах, албаны эрх үүргээ хэтрүүлэх, архидан согтуурах шалтгаан нөхцөл зонхилж байгаа хэдий ч дараах хүчин зүйлсийн улмаас алба хаагчид гэмт хэрэг, зөрчил, сахилга ёс зүйн зөрчилд холбогдож байна гэж дүгнэлээ. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, түргэн шуурхай байдал шаардлагын түвшинд хүрээгүй;
2. Алба хаагчийн соёл, харилцаа, ёс зүйн төлөвшил доголдолтой;

¹ Төрийн албаны тухай хууль. // <http://www.legalinfo.nin/law/details/12189>

² ЦЕГ-ын Дотоод хяналт, аюулгүй байдлын газар, Судалгаа, дүн шинжилгээний төвөөс “Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын тайлангаас харахад 2011-2015 онд хууль зөрчсөн 1143, хүний эрх, эрх чөлөө зөрчсөн 90 удаагийн зөрчил бүртгэгдсэн байна.

3. Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа зохих түвшинд хангагдаагүй;

4. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, сонгон шалгаруулалт зарим тохиолдолд оновчгүй байх зэрэгтэй холбоотой. Мөн олон нийтэд үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод тайлагнахгүй байгаагаас цагдаагийн ажил, үйлчилгээний талаархи ойлголт муу, авилга, хүнд сурталд автагдсан гэх сэтгэгдэл, үл ойлголцол бий болж шүүмжлэлд өртөх, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр захиалгаар цагдаагийн албаны нэр хүндэд халдах, үйл ажиллагаа болон гэмт хэрэг, зөрчлийн талаар сөрөг сурталчилгаа хийх болсон байна.

Түүнчлэн алба хаагчдаас байгууллага, албаны нэрээр цахим хуудас нээж ашиглах, хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны дүрэмт хувцастай зураг оруулах, зөвшөөрөлгүйгээр байгууллагын нэрийн өмнөөс албан ёсны бус мэдээг олон нийтэд хүргэх, нийтлэл бичих зэрэг зөрчил, дутагдал оршсоор байгаа нь мөн л албаны нэр хүнд унах нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд хэвлэл, мэдээллийн байгууллагатай харилцах, гэмт хэрэг, зөрчил, үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хариуцсан нэгж, алба хаагчдаар дамжуулж өгөх, байгууллага, алба хаагч иргэдтэй харилцахдаа хууль, журам, стандартын дагуу харьцаж, харьцааны соёл, биеэ авч явах байдлыг дээшлүүлэх, хувийн цахим хуудсаар алба, үйл ажиллагааны талаар үзэл бодлоо илэрхийлэхийг хориглох чиглэлээр цагдаагийн төв, нутаг дэвсгэр хариуцсан газар хэлтэс, түүний бүтцийн нэгжийн бүх шатны удирдах албан тушаалтан алба хаагчиддаа үүрэг, чиглэл өгч, хяналт тавьж ажиллах шаардлага бий болсныг харуулж байна. Түүнчлэн төв, орон нутгийн газар, хэлтэс албан ёсны цахим хуудасны стандарт жишиг хэрэглээг хэвшүүлэх, албаны цахим хуудсаар нийтэлж байгаа мэдээ, мэдээллийн агуулга, ач холбогдол, үнэн бодит байдлыг сайтар нягталж байх, хариуцсан алба хаагчийн ур чадварыг сайжруулж, мэдээ, мэдээллийг зөвхөн нэг цонхоор түгээж байх нь зүйтэй болохыг өнөөгийн нөхцөл байдал илтгэн харуулж байна.

ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллагын нэр хүндэд эерэг болон сөрөг байдлаар бодитоор нөлөөлж байгаа хүчин зүйлийг гурван үндсэн багц хэсэгт авч үзэж, иргэд, олон нийтийн зүгээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг хэрхэн үнэлж байгаад дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. *Цагдаагийн байгууллагын нэр хүнд* - гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй үйл ажиллагааны бодит байдал, алба хаагчдийн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, сахилга хариуцлагын илрэх хэлбэрт

хөндлөнгөөс өгч буй үнэлэмж. Энэхүү нэр хүнд аяндаа бий болдог нийгмийн үзэгдэл огтоос биш бөгөөд алба хаагч бүрийн хичээл зүтгэл, шат шатны удирдах албан тушаалтны удирдлагын зөв арга барил, түүний хэрэгжилт, хүч чармайлт, олон жилийн шаргуу хөдөлмөр зэрэг олон талт үйл ажиллагааны үр дүнгээр бодит биелэлээ олж хүсэн хүлээсэн нэр хүнд, итгэл үнэмшлийг олж авдаг.

2. Цагдаагийн байгууллагын нэр хүндийг бодитоор тогтоохын тулд түүнд учрах эрсдэлийг тооцох нь чухал бөгөөд өнөөдөр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд учир болох 6 эрсдэл тутмын нэг нь цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл байна.

3. Нийгмийн ёс суртахууны үнэлэмж доройтсон өнөө үед иргэд, олон нийтийн зүгээс цагдаагийн алба хаагчийг албан үүргээ хэрэгжүүлж байгаатай нь холбогдуулан гүтгэх, хэл амаар болон элдэв үйл хөдлөлөөр доромжлох нь ихсэж, цагдаагийн байгууллагын нэр хүнд олон түмний дунд буурахад нөлөөлж буй хамгийн том сөрөг хүчин зүйл болж байна.

4. Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл нэрийн дор хийгдэж байгаа удаа дараагийн өөрчлөлт алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах, тэдний албанд хандах хандлага, итгэл үнэмшил, цаашлаад цагдаагийн байгууллагын нэр хүнд буурахад хамгийн их сөрөг нөлөөлөлийг бий болгож байна.

ДЭВШҮҮЛЭХ САНАЛ

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, түүний удирдлагыг бодитойгоор хангахад чиглэсэн хамгийн оновчтой, тогтвортой, давхцалгүй, зохион байгуулалтын бүтэц бүхий хэвийн ажиллах орчныг бүрдүүлэх, түүнчлэн цагдаагийн албыг мэргэшсэн, тогтвортой байх нөхцлийг хангах хариуцлагын тогтолцоог шат шатанд бий болгох, нэвтрүүлэх;
2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг өргөнөөр ашиглан мэдээлэл, холбооны хоцрогдлыг арилгаж албаны найдвартай, шуурхай, ил тод байдлыг хангахад чиглэсэн иж бүрэн шинэчлэлтийг шуурхай нэвтрүүлэх;
3. Эрсдэлд суурилсан төлөвлөлт, удирдлага, хяналтын системийг бий болгож эрсдлийг бууруулах, саармагжуулах цогц бодлого, хөтөлбөрийг боловсруулж цагдаагийн байгууллагын нэр хүндэд нөлөөлөх эрдслийн удирдлагыг нэгж, алба бүрт үр дүнтэй нэвтрүүлэх.